


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2021 ОНЫ ЭХНИЙ 11 САР)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **15,017.7** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс

27.9 хувь буюу **3,276.0** сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл **2,641.9** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	11 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	11,852.3	12,639.4	11,741.8	15,017.7	3,276.0	27.9
-Экспорт	6,480.7	7,055.6	6,855.1	8,829.8	1,974.6	28.8
-Импорт	5,371.5	5,583.8	4,886.6	6,187.9	1,301.3	26.6
Тэнцэл	1,109.2	1,471.8	1,968.5	2,641.9	673.3	34.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2021 оны эхний 11 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 2,641.9 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 673.3 сая ам.доллар буюу 34.2 хувиар өсөхөд импорт 1,301.3 сая ам.доллар, экспорт 1,974.6 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Экспорт: Экспортын худалдаа 2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 8,829.8 сая ам.долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 1,774.2

сая ам.доллар буюу 25.1 хувиар, харин 2020 оны мөн үетэй харьцуулахад 1,974.6 сая ам.доллар буюу 28.8 хувиар өссөн байна.

Импорт: 2021 оны эхний 11 сарын байдлаар импорт 6,187.9 сая ам.доллар болж 2019 оны мөн үетэй харьцуулахад 604.1 сая ам.доллар буюу 10.8 хувиар, 2020 оны мөн үеэс 1,301.3 сая ам.доллар буюу 26.6 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **82.3** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **17.7** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **7,266.4** сая ам.долларт хүрч, өмнөх оноос **2,511.8**

сая ам.доллар буюу 52.8 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **1,563.4** сая ам.доллар болж, өмнөх оноос **537.1** сая ам.доллар буюу **25.6** хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	11 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	5,596.7	5,978.0	4,754.7	7,266.4	2,511.8	52.8	82.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	884.0	1,077.6	2,100.5	1,563.4	-537.1	-25.6	17.7
Нийт экспорт	6,480.7	7,055.6	6,855.1	8,829.8	1,974.6	28.8	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 32.1 хувийг зэсийн баяжмал, 29.4 хувийг нүүрс, 10.8 хувийг төмрийн хүдэр, 10.5 хувийг боловсруулаагүй

алт, 3.1 хувийг боловсруулаагүй нефть, 2.0 хувийг цайрын хүдэр, 1.6 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	11 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,311.5	1,292.7	1,256.3	1,256.7	0.4	0.03
Нүүрс	сая.тн	33.4	34.8	27.0	15.2	-11.8	-43.8
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	6.7	7.6	7.6	7.1	-0.5	-6.9
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	113.8	124.7	123.4	112.6	-10.8	-8.8
Алт	тн	3.4	7.5	27.7	15.9	-11.8	-42.7
Боловсруулаагүй нефть	сая.баррель	5.7	6.0	3.6	4.3	0.8	22.1
Катодын зэс	тн	12.0	10.0	6.3	9.3	3.0	46.9
Жоншны баяжмал	мян.тн	492.5	631.0	605.5	635.5	30.0	5.0
Адууны мах	мян.тн	26.2	22.7	16.9	7.0	-9.9	-58.5
Өлөн гэдэс	тн	376.5	353.4	493.6	494.1	0.5	0.1

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	67.1	64.4	23.4	7.5	-15.9	-68.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.3	592.8	340.0	441.4	101.4	29.8
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	115.4	50.6	45.2	66.3	21.0	46.5
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	121.8	113.9	79.8	75.5	-4.3	-5.4
Самнасан ноолуур	тн	611.9	461.8	246.8	374.3	127.5	51.7
Бохир ноолуур	тн	5,274.9	5,686.0	6,070.3	4,681.9	-1,388.4	-22.9
Хонины самнаагүй ноос	мян.тн	11.7	13.5	6.9	5.5	-1.4	-20.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	11 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,824.2	1,671.0	1,528.4	2,835.3	1,307.0	85.5
Нүүрс	2,617.1	2,943.9	2,002.9	2,598.0	595.1	29.7
Төмрийн хүдэр	307.5	519.2	585.8	950.6	364.8	62.3
Цайрын баяжмал	183.6	175.3	152.4	176.4	24.1	15.8
Алт	144.5	344.3	1,624.7	924.8	-699.9	-43.1
Боловсруулаагүй нефть	366.7	334.8	128.3	273.4	145.1	113.1
Катодын зэс	76.7	57.5	34.5	83.3	48.8	141.3
Жоншны баяжмал	165.8	187.2	140.1	141.8	1.7	1.2
Адууны мах	53.8	42.9	31.8	14.6	-17.2	-54.1
Өлөн гэдэс	7.2	7.4	8.3	12.1	3.8	46.4
Үхэр, адууны боловсруулсан шир	7.3	5.8	2.3	0.8	-1.5	-65.3
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	1.8	0.5	0.7	0.3	51.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	3.1	1.1	0.9	1.3	0.4	41.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	4.3	3.8	2.9	2.4	-0.5	-16.4
Самнасан ноолуур	53.1	41.0	16.1	34.4	18.3	113.9
Бохир ноолуур	251.2	283.2	178.1	191.5	13.5	7.6
Хонины самнаагүй ноос	19.1	18.9	7.3	5.6	-1.7	-23.2
Нийт экспортод эзлэх хувь	93.9%	94.1%	94.0%	93.4%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **2,511.0** сая ам.доллар буюу **52.8** хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1. Нүүрс: 2021 оны эхний 11 сарын байдлаар **15.2** сая тонн нүүрс экспортолж, **2,598.0** сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 11.8 сая тонноор буурсан боловч экспортын орлого 595.1 сая ам.доллараар буюу 19.7 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 94.8 ам.доллар буюу 127.7 хувиар нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлого өсөхөд нөлөөлжээ.

2.Зэсийн баяжмал: 2021 оны эхний 11 сарын байдлаар зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 85.5 хувь буюу 1,307.0 сая ам.доллараар нэмэгдэж, **2,835.3** сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ **1,256.7** мянган тоннд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 0.03 хувь буюу 0.4 мянган тонноор өссөн ба экспортын дундаж үнэ 85.4 хувиар өссөн байна.

3.Төмрийн хүдэр: 2021 оны эхний 11 сарын байдлаар төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ **7.1** сая тонн болж, **950.6** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 62.3 хувь буюу 364.8 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 6.9 хувь буюу 0.5 сая тонноор буурсан боловч 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 73.7 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

4.Цайрын баяжмал: 2021 оны эхний 11 сарын байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ **112.6** мянган тонн болж, **176.4** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 15.8 хувь буюу 24.1 сая ам.доллараар өсөхөд цайрын баяжмалын биет хэмжээ 8.8 хувь буюу 10.8 мянган тонноор буурсан боловч 1 тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 26.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

5. Боловсруулаагүй нефть: 2021 оны эхний 11 сарын байдлаар боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ **4.3** сая баррельд хүрч, **273.4** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Боловсруулаагүй нефтийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 113.1 хувь буюу 145.1 сая ам.доллараар өсөхөд биет хэмжээ эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үеэс 1.6 сая баррель буюу 27.5 хувиар буурсан боловч өмнөх оны мөн үеэс 22.1 хувь буюу 0.8 сая баррелиар өссөн, мөн тайлант хугацаанд 1 тонн түүхий газрын тосны экспортын дундаж үнэ 78.4 хувиар нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

6. Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2021 оны эхний 11 сарын байдлаар катодын зэсийн экспортын тоо хэмжээ **9.3** тоннд хүрч, **83.3** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Катодын зэсийн экспортын орлого 2019 оны мөн үеэс 6.8 хувь буюу 0.7 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 120.4 хувь буюу 41.6 сая ам.доллараар өссөн нь катодын зэсийн биет хэмжээ 46.9 хувь буюу 0.8 тонноор өссөн, 1 тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 63.6 хувиар нэмэгдсэн зэрэг нөлөөлсөн байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **18.9** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **81.1** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,169.9** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **252.2** сая ам.доллараар буюу 27.5 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 5,018.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс **1,049.1** сая ам.доллар буюу 26.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	11 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,203.1	1,239.1	917.7	1,169.9	252.2	27.5	18.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,168.4	4,344.7	3,968.9	5,018.1	1,049.1	26.4	81.1
Нийт импорт	5,371.5	5,583.8	4,886.6	6,187.9	1,301.3	26.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 18.9 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 18.3 хувь, автотээвэр, агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги 18.2 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 14.0 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.7 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 8.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2020.11	2021.11	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	71.9	109.0	37.1	51.6	1.8
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	105.9	171.0	65.1	61.5	2.8
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	30.5	40.3	9.8	32.2	0.7
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	402.6	544.3	141.7	35.2	8.8
5	Эрдэс бүтээгдэхүүн	917.7	1,169.9	252.2	27.5	18.9
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	340.9	526.2	185.3	54.3	8.5
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	209.8	228.6	18.7	8.9	3.7
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	4.7	5.9	1.2	25.3	0.1
9	Мод, модон эдлэл	42.3	55.8	13.5	31.9	0.9
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	49.6	56.8	7.2	14.5	0.9
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	78.7	92.0	13.3	16.9	1.5
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	16.9	21.4	4.5	26.5	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	158.3	149.7	-8.6	-5.5	2.4
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	2.8	5.6	2.8	98.2	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	512.6	541.0	28.4	5.5	8.7
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	978.7	1,133.3	154.6	15.8	18.3
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	796.0	1,128.9	332.9	41.8	18.2
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг тэдгээрийн эд анги	82.1	115.7	33.6	40.9	1.9
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	10.6	2.6	-8.0	0.0	0.0
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	73.5	89.3	15.8	21.5	1.4
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.05	0.2	0.1	228.0	0.002
	ДҮН	4,886.6	6,187.9	1,301.3	26.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортод нөлөөлсөн хүчин зүйлс: Эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж гадаад худалдааны бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 25.6 хувиар илүү гарсан. Манай улс Коронавируст цар тахал /КОВИД-19/-ын дэгдэлттэй холбогдуулан 2021 оны 02 болон 04 дүгээр саруудад бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорио тогтоосноор ААН, иргэдийн импортоор орж ирсэн ачаа, бараагаа авч, гаалийн бүрдүүлэлт хийх үйл ажиллагаа удааширсан. Мөн түүнчлэн 2021.10.13-ны өдрөөс БНХАУ-ын Эрээн хотын боомт тодорхойгүй

хугацаагаар хилээ хаасантай холбоотойгоор татвар, хураамжийн орлогын төлөвлөгөө 91.0 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2021 оны эхний 11 сард 3,256.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 3,165.2

тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 97.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020.11		2021.11		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь	
Нийт орлого	2,650.9	3,256.2	3,165.2	514.3	119.4	-91.0	97.2	
Гаалийн албан татвар	684.6	849.9	852.2	167.6	124.5	2.3	100.3	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,384.2	1,749.4	1,708.3	324.1	123.4	-41.1	97.7	
Архи, дарсны онцгой албан татвар	9.7	12.9	16.1	6.4	166.0	3.2	124.8	
Тамхины онцгой албан татвар	112.3	125.4	121.0	8.7	107.7	-4.4	96.5	
Шар айрагны онцгой албан татвар	1.9	2.0	5.2	3.3	273.7	3.2	260.0	
Суудлын автомашины онцгой албан татвар	158.6	187.8	189.0	30.4	119.2	1.2	100.6	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	220.5	238.1	214.3	-6.2	97.2	-23.8	90.0	
Автобензин, дизель түлшний албан татвар	15.9	13.5	14.7	-1.2	92.5	1.2	108.9	
Экспортын татвар	0.012	0.0242	0.037	0.025	0.0	0.0	0.0	
Татварын дүн	2,587.7	3,179.0	3,120.8	533.1	120.6	-58.2	98.2	
Өөрийн орлого	5.3	20.2	5.0	-0.3	94.3	-15.2	24.8	
Хураамж	57.9	57.0	39.4	-18.5	68.0	-17.6	69.1	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого **514.3** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар **167.6** тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **324.1** тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар **6.4** тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар **8.7** тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар **3.3** тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар **30.4** тэрбум төгрөг;
- Экспортын гаалийн албан татвар **25.0** сая төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар **6.2** тэрбум төгрөг, автобензин, дизель түлшний албан татвар **1.2** тэрбум төгрөг, өөрийн орлого **0.3** тэрбум төгрөг, хураамжийн орлого **18.5** тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 51,643 ширхэгийг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,326 ширхэг буюу 4.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 3,593 ширхэгээр өссөн бол, бусад суудлын автомашин 1,267 ширхэгээр буурсан байна.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Импортын тоо хэмжээ				Ногдуулсан татвар			
	2020.11	2021.11	Зөрүү	Хувь	2020.11	2021.11	Зөрүү	Хувь
Төрөл								
Хос тэжээлт	35,166	38,759	3,593	110.2	95.7	120.6	24.9	126.0
Бусад	14,151	12,884	-1,267	91.0	62.6	67.7	5.0	108.0
Нийт	49,317	51,643	2,326	104.7	158.3	188.2	29.9	118.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2020 оны эхний 11 сард 1,463.6 мянган тонн, 2021 оны эхний 11 сард 1,399.9 мянган тонн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуульд заасан дагуу газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд тонн тутамд 285.0 мянган төгрөгийн онцгой албан татварыг 2021 оны 08 дугаар сарын 01-нээс эхлэн ногдуулж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл		Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар			
		2020.11	2021.11	Зөрүү	Хувь	2020.11	2021.11	Зөрүү	Хувь
Нийт		1,463.6	1,399.9	-63.7	95.6	215.6	207.0	-8.7	96.0
Автобензин	A-80	52.7	53.3	0.6	101.1	-	0.0	-	-
	A-92	464.8	434.0	-30.8	93.4	-	0.0	-	-
	A-95 болон түүнээс дээш	29.5	24.9	-4.5	84.6	6.1	5.2	-0.9	85.6
Дизель түлш		916.6	887.7	-29.0	96.8	209.5	201.8	-7.8	96.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хураамжийн орлого: Улсын төсөвт хураамжийн орлогоор 57.0 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 39.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 69.1 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 18.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Экспортоор гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн 92.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хураамжийн орлого /мянган тонн, сая төгрөг/

Экспортын эрдэс бүтээгдэхүүний гол нэрийн бараа	2020.11		2021.11		өөрчлөлт 2021/2020	
	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж
Жонш	605.5	908.2	635.5	953.2	30.0	45.1
Төмрийн хүдрийн баяжмал	7,617.6	11,426.3	7,091.9	10,637.8	-525.7	-788.5
Зэсийн баяжмал	1,256.3	1,884.5	1,256.0	1,884.1	-0.3	-0.4
Цайрын баяжмал	123.4	185.2	112.6	168.9	-10.8	-16.3
Чулуун нүүрс	26,998.0	40,496.9	15,160.7	22,741.1	-11,837.2	-17,755.8
Хүрэн нүүрс	74.8	112.2	32.3	48.4	-42.5	-63.8
Түүхий нефть/мянган баррель/	3,562.7	5.3	4,348.9	6.5	786.2	1.2
Бусад		15.0		654.3		639.3
Нийт		55,033.6		37,094.3		-17,939.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тав. Татварын чөлөөлөлт

2021 оны эхний 11 сарын байдлаар нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр 1,816.7 тэрбум төгрөг буюу нийт импортын 10.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 3,226.0 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин, татвараас чөлөөлөгдсөн

импорт 636.1 тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **1.7** нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020.11	2021.11	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	12,581.1	15,807.2	3,226.0	125.6%
<i>Эзлэх хувь</i>	<i>91.4%</i>	<i>89.7%</i>	<i>-1.7%</i>	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,180.6	1,816.7	636.1	153.9%
<i>Эзлэх хувь</i>	<i>8.6%</i>	<i>10.3%</i>	<i>1.7%</i>	
Нийт импорт	13,761.7	17,623.9	3,862.2	128.1%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2021 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1,816.7 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох **302.9** тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **95.8** тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос зэрэг 320.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **48.9** тэрбум төгрөгийн татвар;
2. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 254.8 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **41.4** тэрбум төгрөгийн татвар;
3. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016.09.07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-ийн хүрээнд 258.6 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **66.6** тэрбум төгрөгийн татвар;
4. Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд 109.6 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **16.7** тэрбум төгрөгийн татвар;
5. Иргэний агаарын тээврийн зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг 93.5 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **14.5** тэрбум төгрөгийн татвар;
6. Бусад төрлийн барааны хувьд татварын холбогдох хуулийн зүйл, заалтуудаар 601.1 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **91.6** тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Д/д	Үзүүлэлт	2020.11		2021.11		Өөрчлөлт (2021/2020)	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	157.3	24.4	320.7	48.9	163.4	24.5
2	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	370.9	87.3	258.6	66.6	-112.3	-20.7
3	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	132.3	19.5	109.6	16.7	-22.8	-2.8
4	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	34.5	5.4	93.5	14.5	59.0	9.1
5	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын зээл	198.6	29.9	254.8	41.4	56.2	11.5
6	Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж	64.8	10.1	73.9	11.5	9.0	1.3
7	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	6.4	0.9	28.9	3.7	22.5	2.8
8	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	50.4	5.0	75.6	7.9	25.2	2.9
9	Бусад	165.2	24.5	601.1	91.6	435.9	67.1
	Дүн	1,180.6	207.0	1,816.7	302.9	636.1	95.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Коронавируст цар тахлын үед авч хэрэгжүүлж байгаа татварын чөлөөлөлтийн арга хэмжээ: Дэлхий нийтэд тархаад байгаа Коронавируст цар тахал /КОВИД-19/-ын дэгдэлттэй холбоотойгоор гаргасан шийдвэрүүдийг үндэслэн гаалийн байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

1. 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан “Бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг Гаалийн албан татвар болон НӨАТ-аас чөлөөлөх тухай” хуулийн хүрээнд 2021 оны эхний 11 сарын байдлаар 195 аж ахуйн нэгж, 1 хувь иргэний импортолсон нийт **112.5** сая ам.долларын нэр төрлийн бараанд ногдох **48.9** тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн байна.

2. Коронавируст цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг татвараас чөлөөлөх тухай чиглэл өгснөөр дараах хууль, тогтоолуудыг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

•Засгийн газрын 2009 оны 335 дугаар тогтоол /томуугийн А хүрээний (H1N1) вирусийн оношилгоо, эмчилгээний/;

•Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсанаар дагаж гарсан Засгийн газрын 132-р тогтоолын хүрээнд эхний 11 сарын байдлаар 200 гаруй аж ахуйн нэгж, 1 хувь иргэний импортолсон нийт **183.5** сая ам.долларын нэр төрлийн бараанд ногдох **80.8** тэрбум төгрөгийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна.

3.Цар тахлын үед хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд татварын дэмжлэг үзүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл, тогтвортой нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн шинэ трактор комбайн, тоног

төхөөрөмжийг энэ оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс он дуустал гаалийн албан татвараас хөнгөлж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийг хэрэгжүүлж эхэлснээр 2021 оны эхний 11 сарын байдлаар 151 аж ахуйн нэгж, 27 хувь иргэний импортолсон нийт **26.1** сая ам.долларын бараанд ногдох **7.8** тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг чөлөөлсөн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС